

## Завхан аймгийн хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал

**Д. Бямбадорж, докторант**

*МУИС-ийн Завхан сургуулийн эдийн засаг,  
математикийн тэнхимийн багш*

Хүн өөрийн мэдлэг чадварыг хэр зэрэг ашиглаж чадаж байна, ашиглах боломж бүрдэж байна уу? зэрэг асуулт ар араасаа урган гарч байгаагаас харахад эдийн засагчид хөдөлмөрийн зах зээлийн асуудлыг олон өнцгөөс авч үзэн илүү нарийвчлан судалж байна.

Аливаа улс орны хөгжлийн чиг хандлага, хурдыг тодорхойлдог гол хүчин зүйл хөдөлмөр юм. Иймд эдийн засгийн салбарын бүтцэд ихээхэн өөрчлөлт гарч байгааг олон талаас холбон судлах, үр дүнг тоо баримт мэдээллээр баталгаажуулан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, тэнцвэр, түүний өөрчлөлтийг тодорхой давтамжтайгаар байнга судлах эрэлт бас үүсч байгаа болно. Тэр тусмаа төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, бизнесийн орчныг сайжруулах явдал чухал байгааг нийтээрээ хүлээн зөвшөөрөөд байгаа үед хөдөлмөр эрхлэлтийг капитал бараа үйлдвэрлэлийн салбарт илүү дэмжих үү, аль эсвэл өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэлийн салбарт хандуулан хөгжүүлэх үү гэсэн зарчмын сонголт тулгарч байна.

Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэгч гол хүчин зүйлсийн нэг нь хүмүүн капиталын хөрөнгө оруулалт юм. Цалингийн ялгаатай байдлыг зөв ойлгох буюу бусдаас өндөр цалин авахын тулд тухайн ажилчин өөрийн мэдлэг чадвар болон боловсролыг дайчлах шаардлагатай болж байна. Иймд хүмүүн капиталын хөрөнгө оруулалт нь ирээдүйд бий болох баялаг, сайн сайхан байдал, орлогын итгэл, хүлээлтийг харуулна. Энэ бүгдийг нэгтгэвэл, хөдөлмөрийн нэг цагийн үнэ болон бодит худалдан авах чадварын харилцан хамаарал бодитой мэдээллийн үндсэн дээр аймаг бүрээр гүйцэд судлагдаагүй байгаа тул зүй ёсоор анхаарал хандуулах ёстой асуудал гэж үзэж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд хамаарах дээрх асуудлын шинж байдлыг Завхан аймгийн хувьд тодорхойлохыг энэ ажлын хүрээнд зорьж байгаа болно.

### **Түлхүүр үгс:**

Хүн ам, хөдөлмөрийн насны хүн ам, ажиллах хүчний оролцооны түвшин, ажил эрхлэлтийн түвшин, ажилчид, ажилгүйдлийн түвшин, ажилгүйчүүд, хөдөлмөрийн бүтээмж

### **Завхан аймгийн хөдөлмөрийн нөөц, түүний ашиглалтын судалгаа**

Завхан аймаг хөдөлмөрийн ямар нөөцтэй вэ? Хөдөлмөрийн нөөцөө бүрэн ашиглаж

чадаж байна уу? Хөдөлмөрийн нөөцөө ашиглаж чадахгүй байгаа тохиолдолд алдагдсан боломжийн өртөг ямар байна вэ? зэрэг асуултаудын хариултыг хөдөлмөрийн зах зээлийн голлох дараах гурван үзүүлэлтийн дагуу Хүснэгт 1-д харуулав.

**Хүснэгт 1. Ажиллах хүчний оролцоо, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, оноор**

Үзүүлэлтүүд	Он					Дундаж
	2004	2005	2006	2007	2008	
Ажиллах хүчний оролцооны түвшин %	77.8	79.4	78.2	78.3	76.5	78.1
Ажил эрхлэлтийн түвшин %	73.8	75.4	74.7	75.6	73.3	74.6
Ажилгүйдлийн түвшин %	5.2	5.0	4.5	3.7	4.2	4.5

Эх сурвалж: Завхан аймгийн статистикийн хэлтэс, 2010

Хүснэгтээс харахад Завхан аймаг хөдөлмөрийн нөөцөө бүрэн үнэлэх боломжгүй байгаа бөгөөд авч үзэж буй дөрвөн жилийн дунджаар хөдөлмөрийн насны хүн амын дөнгөж 78% нь ажиллах хүчний бүрэлдэхүүнд хамрагдаж байна. Албан ёсны ажилтай хүмүүсийн бүртгэл бүрэн бүртгэгдэж байгаа ч ажилгүйчүүдийн бүртгэл хангалтгүй байна.

2004-2008 оны дунджаар хөдөлмөрийн насны хүн амын 74% нь ажиллагсад байгаа бол ажиллах хүчний оролцооны түвшин 78% гэж үзэхэд дөнгөж хөдөлмөрийн насны хүн амын 4% нь л ажилгүйчүүд байна гэж үзэж

болохоор байна. Гэвч бодит байдал дээр ийм биш юм.

Ажилгүйдлийн түвшин буурч байгаа боловч ажилгүйчүүд ажиллах хүчинд бага жинг эзэлж байгаа нь ажилгүйдлийн бүртгэлтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, хөдөлмөр халамжийн хэлтэст бүртгүүлээгүй хувиараа ажил хайж байгаа хүмүүс нь ажилгүйчүүдийн бүртгэлд ордоггүй, харин эдийн засгийн идэвхигүй хүн амд ордогтой холбоотой юм. Тиймээс хөдөлмөрийн насны ажил эрхэлдэггүй хүн амын ажил эрхлээгүй шалтгааныг тодруулсныг Хүснэгт 2-оос харна уу.

**Хүснэгт 2. Хөдөлмөрийн насны ажил эрхэлдэггүй хүн амын хувь**

Үзүүлэлт	2005	2006	2007	2008
Ажил эрхэлдэггүй хүний тоо	100.0	100.0	100.0	100.0
<b>Шалтгаан</b>				
- Хүндэтгэх шалтгаанаар ажил эрхэлдэггүй	41.2	38.3	42.2	44.3
- Хүүхэд асардаг	19.9	19.1	17.1	21.3
- Өвчтөн, өндөр настан асардаг	4.3	3.9	3.8	5.6
- Өөрөө өвчтэй	2.3	1.9	2.2	1.8
- Гэр бүлийн хүний ажлын онцлогоос	1.1	1.8	1.5	1.0
- Гэрийн ажилтай	13.6	11.7	17.6	14.5
- Бусад шалтгаанаар ажил эрхэлдэггүй	58.8	61.7	57.8	55.7
- Ажил хайж байгаа	0.0	13.5	0.0	0.0
- Тохирох ажил олдохгүй байгаа	27.0	13.6	20.9	13.3
- Засан хүмүүжүүлэх газраас суллагдсан	0.2	0.2	0.1	0.0
- Хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй	0.5	0.7	0.2	0.4
- Тодорхой шалтгаангүй	31.1	33.7	36.7	41.9
Бүгдээс: Урьд ажил хайж байсан	14.7	15.3	8.3	0.0

Эх сурвалж: Завхан аймгийн статистикийн хэлтэс, 2010

2008 оны байдлаар хөдөлмөрийн насны ажил эрхэлдэггүй хүн амыг шалтгаанаар авч үзэхэд “хүндэтгэх шалтгаанаар ажил эрхэлдэггүй” гэсэн үндэслэлээр 44,3 хувьтай байхад “бусад шалтгаанаар ажил эрхэлдэггүй” гэсэн хүмүүс 55,7%, үүнээс тодорхой шалтгаангүйгээр ажил эрхэлдэггүй хүмүүс 41,9 хувьтай байгаа нь анхаарал ихэд татаж, өнөөдөр бидний амьдралын түвшин ийм хангалттай юу? гэсэн асуулт тавихад хүргэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн бодит тоог “ажил хайж байгаа”, “тохирох ажил олдохгүй байгаа” гэсэн үндэслэлээр ажил эрхэлдэггүй хүмүүсээр нэмэгдүүлж болно. Иймээс хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэгдэж, түүгээр дамжуулан ажилд орохын ач холбогдлыг нийтэд сурталчилах, ажил ба хүмүүсийн ажлын байрны сонирхлын хоорондын харилцан хамаарлыг илүү нарийвчлан судлах зайлшгүй шаардлага урган гарч байна.

**Хүснэгт 3. Хөдөлмөрийн насны суралцагчдын тоо, сургуулийн төрөл, оноор**

Үүнээс: сургуулийн төрлөөр

Он	Нийт	Бүгд							
		Их, дээд сургууль	Коллеж	Тусгай дунд мэргэжлийн	ЕБС	Шашны	Үйлдвэр сургалтын төвд	Мэргэжлийн дамжаанд	
2005	3258	838	75	20	1955	17	350	3	1823
2006	3634	1005	126	36	2144	23	297	3	1777
2007	3952	1207	255	78	2054	31	327	0	2060
2008	3498	974	143	28	2008	10	131	204	1854


Хөдөлмөрийн насны суралцагчдаас дийлэнх хэсгийг ЕБС-д суралцагчид эзэлж байна. Энэ нь хөдөлмөрийн насыг 16 наснаас дээш гэж үздэгтэй холбоотой. Дараа нь их, дээд сургууль, коллежид суралцагчид байна. Ер нь сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн насны суралцагчдын нэмэгдэж байгаа бөгөөд үүнийг залуучуудын суралцах хүсэл сонирхол нэмэгдэж байгаагаар буюу боловсролын индексийн өсөлтөөр батлан харуулж болно. 2007 оны байдлаар манай орон хүний хөгжлийн индексээр 114-р байр эзэлж байхад боловсролын индексээр тодруулбал, насанд хүрэгсдийн бичиг үсэг тайлагдалтын индексээр 25-р байр, бүх шатны сургуульд хамрагдалтын индексээр 66-р байр тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл, Монгол орны хүний хөгжлийн индексийг нэмэгдүүлдэг гол хүчин зүйл боловсролын индекс гэж үзэж болно. Залуучуудын цаашид суралцах хүсэл сонирхол нь өөрийн хүмүүн капиталын хөрөнгө

оруулалтыг нэмэгдүүлэх, түүгээр дамжуулан өөрийн бүтээмжийг, үнэлгээг нэмэгдүүлэх, ирээдүйн амьдралын сайн сайхны баталгааг бий болгодог. Эндээс харахад Завхан аймгийн хэмжээгээр хөдөлмөрийн насны суралцагчдыг дэмжих цагийн буюу гэрээт ажлын боломжийг гүнзгийрүүлэн судалж, боломжийг тодорхойлох хэрэгцээ бас байна.

**Ажилгүйдэл, ажилгүйдлийн түвшинг цаг хугацаанаас хамааруулсан үнэлгээ**

Ажилгүйчүүдийг цаг, хугацаанаас хамааруулан хандлагыг тодорхойлон авч үзвэл (энд бусад хүчин зүйл тогтмол гэсэн нөхцөл тавигдсан), ажилгүйдэл хугацааны хувьд буурах хандлагатай. Ажилгүйдэл ба цаг хугацааны хоорондын хамаарлыг эконометрикийн хамгийн бага квадратын аргаар шугаман регрессийн тэгшитгэлээр үнэлэв (EViews программ ашиглав).

**Зураг 1. Ажилгүйдлийн хандлагын шугаман байдал, Завхан аймаг, 1992-2008**



y - ажилгүйдлийн ажиглалтын утга  
t- хугацаа  
yt - ажилгүйдлийн онолын утга

**Зураг 2. Ажилгүйчүүд хандлагын энгийн дундаж, Завхан аймаг, 1992-2008**



$$Y = 4421.3 - 213.9 \cdot T$$

**Корреляцийн матриц**

	Y	T
Y	1.000000	-0.800617
T	-0.800617	1.000000

Дээрх шинжилгээнээс харахад үнэлгээний хувьд ач холбогдолтой гэдэг нь харагдаж байна. Ажилгүйдэл цаг, хугацаанаас урвуу хамааралтай, хугацаа өнгөрөх тусам ажилгүйдэл буурах хандлагатай байна.

- R2= 0.64 бидний авч үзэж буй тэгшитгэл ажиглалтын утгыг 64 хувьтайгаар тайлбарлагдаж чадаж байна. Мөн R2 болон засварлагдсан R2 зөрүү бага байна.
- C буюу тогтмол параметр C = 4421.3 өндөр утгатай байгаа нь ажилгүйдэл цаг, хугацаанаас өөр бусад олон хүчин

зүйлээс хүчтэй хамаарна гэдэг нь илэрхий юм.

- Prob. Утгууд тэгтэй ойролцоо. (H0=0 таамаглалыг хүлээн зөвшөөрөхгүй буюу параметрууд ач холбогдолтой.)
- DW stat=1.72 буюу авто корреляцигүй байна.

Ажилгүйдлийг дотоодын нийт бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн тооноос хамааруулж үзсэн үнэлгээний үр дүн дараах байдалтай.

**Корреляцийн матриц**

	UNEMP	GDP	X2
UNEMP- ажилгүйчүүдийн тоо	1.000000	-0.972670	-0.237843
GDP- Завхан аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн	-0.972670	1.000000	0.304926
X2- үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн тоо	-0.237843	0.304926	1.000000

Үнэлгээний хувьд ач холбогдолтой буюу бидний авч үзэж буй регрессийн тэгшитгэл ажиглалтын утгыг 90 хувьтайгаар тайлбарлаж байна. Үүнийг дараах байдлаар бататгаж болох юм.

- R2=0.90 бидний авч үзэж буй тэгшитгэл ажиглалтын утгыг 90 хувьтайгаар тайлбарлагдаж чадаж байна. Мөн R2 болон засварлагдсан R2 (Adjusted R-squared=0.86) зөрүү бага байна.
- Prob. Утгууд тэгтэй ойролцоо. (H0=0

таамаглалыг хүлээн зөвшөөрөхгүй буюу праметрууд ач холбогдолтой.)

- DW stat=2.821530 буюу авто корреляцигүй байна.

Ажилгүйдэл нь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн, үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн тооноос урвуу хамааралтай байна. Аж ахуй нэгжийн тоо нэмэгдэхэд ажилчдын тоо дагаад нэмэгддэг тул энэ ажилгүйдэлтэй урвуу хамааралтай байгаа ба

## Монголын Хүн Амын Сэтгүүл, дугаар 19

корреляцийн коэффициент -0.237843 байна. Мөн ААН ба ДНБ-ний хамаарлын корреляцийн коэффициент 0.304926 байна. Энэ хамаарал нь ойлгомжтой бөгөөд аж ахуй нэгжийн тоо нэмэгдэхэд нийт бүтээгдэхүүний гарц өсч, улмаар дамжин дотоодын нийт бүтээгдэхүүн нэмэгдэнэ.

Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нь эдийн засгийн өсөлтийг, мөн хүмүүсийн

сайн сайхан амьдрах нөхцөл бололцоо бүрдэж байгааг харуулдаг. Эдийн засгийн өсөлт нь ажилгүйдлийг бууруулах нөхцөл бололцоог бүрдүүлдэг учраас дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, ажилгүйдэлтэй урвуу хамааралтай байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн ба ажилгүйдлийн хоорондын хамаарлын хүчийг харуулагч корреляцийн коэффициент -0.972670 байна.

### Хүснэгт 4. Завхан аймагт ажиллагсдын хувь, мэргэжил, оноор

Мэргэжил	2005	2006	2007	2008
Бүгд	100.00	100.0	100.0	100.0
- Хууль тогтоогч, удирдах ажилтан, менежер	1.86	1.96	2.01	2.71
- Мэргэжилтэн	8.14	8.13	8.14	8.67
- Инженер техникийн ажилтан	1.38	1.28	1.46	1.30
- Клерк бичиг хэргийн туслах ажилтан	0.73	0.71	0.76	0.69
- Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр, зах зээл дээр худалдаа эрхлэгч	14.15	14.88	15.48	11.69
- ХАА, загас агнуурын ажилчид	46.25	50.74	53.84	53.40
- Үйлдвэрлэлийн ажилчид	4.15	2.37	2.33	2.30
- Машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	0.48	0.47	0.49	0.41
- Энгийн ажил гүйцэтгэгчид	22.85	19.45	15.50	18.81

Эх сурвалж: Завхан статистикийн хэлтэс, 2010

Завхан аймгийн хувьд сүүлийн дөрвөн жилийн хугацаанд ажил мэргэжлийн хувьд төдийлөн өөрчлөлт ороогүй, тогтвортой харагдаж байна (Хүснэгт 4). Гол бизнесийн

орчны чанар хэр дээшилсэн бэ, ажиллагсдын ур чадвар нэмэгдэж байгаа юу, хэр зэрэг баялаг бүтээж байна вэ гэдэг асуултын хариулт өнөөг хүртэл гүйцэд судлагдаагүй байна.

### Хүснэгт 5. Завхан аймгийн ажиллагчдын тоо, боловсролын түвшин, оноор

	2005	2006	2007	2008
Бүгд	35816	36150	37344	34770
Дээд	2601	2823	3102	3066
Тусгай мэргэжлийн бүрэн бус дээд	3205	3278	3417	3705
Техник мэргэжлийн анхан шатны	4923	5027	5491	4159
Бүрэн дунд	9154	9470	10005	9352
Бүрэн бус дунд	11055	10958	11079	10571
Бага	4266	4098	3815	3402
Боловсролгүй	612	496	435	515

Эх сурвалж: Завхан статистикийн хэлтэс, 2010

Бүрэн бус дунд боловсролтой ажиллагсдын нийт ажиллагсдад эзлэх хувийн жин өндөр байна (Хүснэгт 5). Энэ нь бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч албан

тушаалтнаас гүйцэтгэх албан тушаалтнуудын тоо харьцангуй их байдгийг харуулж байгаа ба 2007-2008 онд бүрэн бус дунд боловсролтой ажилчдын тоо буурах хандлагатай байна.

**Хүснэгт 6. Ажилчдын тоо, байгууллагын өмчийн хэлбэр, оноор**

Өмчийн хэлбэр	2005	2006	2007	2008
Бүгд	35816	36150	37344	34770
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч	26857	27004	27673	2576
- Нөхөрлөл	226	206	226	123
- Хоршоо	1091	1050	916	804
- Хувьцаат компани	1067	1092	1138	922
- ХХК	604	686	808	739
- Төрийн өмчит үйлдвэрийн газар	453	442	454	403
- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	58	59	69	184
- Төрийн төсөвт байгууллага	5296	5427	5839	544
- Төрийн бус байгууллага	164	184	221	171

Эх сурвалж: Завхан статистикийн хэлтэс, 2010

Завхан аймагт сүүлийн жилүүдэд хүн амын төрөлт ихсэж, 16-аас доош насны хүн амын тоо нэмэгдэж байна. Харин энэ хугацааны өмнөх агшинд төрөлт бага байсан нь 16-19 насныхны нийт хүн амд бага хувь эзэлж байгаагаар илэрхийлж болох юм. Үүнээс гадна хүн амын нас, хүйсийн бүтцийг эдийн засагтай холбон авч үзэхэд манай аймгийн хүн амын насны бүтэц нь нийт хүн амын дийлэнх хэсгийг хөдөлмөрийн насны хүн ам, тэр дундаа 20-24, 25-29, 30-34 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд энэ насныхны ажилгүйдэл өндөр<sup>7</sup> байгаа. Тиймээс яг одоо баялгийг бүтээгч энэ насныхнаар одоо л баялгийг бүтээлгэхгүй бол энэ хэсгийг ашиглаж чадахгүйгээр тэтгэврийн нас руу шилжүүлж, тэжээлгэгчийн тоог нэмэгдүүлэх болоод байна. Өөрөөр хэлбэл, энэ насныхны алдагдсан боломжийн өртөг бусад хэсгээс өндөр байна.

**Дүгнэлт**

Ажиллагсдыг боловсрол, ажиллаж буй салбар, аж ахуй нэгжийн өмчийн харъяалал зэргээр судлав.

Боловсролоор авч үзэхэд сүүлийн жилүүдэд дээд ба бүрэн бус дээд мэргэжилтэй хүмүүсийн тоо өсч байна. Энэ нь сүүлийн үеийн залуучуудын сурах сонирхлыг нэмэгдүүлж байна. Нөгөө талаас, залуучуудын боловсролын хөрөнгө оруулалт нь тэдний бүтээмжийг нэмэгдүүлэх ба хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын үр дүн юм. Мөн боловсролоор амьдралаа баталгаажуулах ба боловсрол эзэмшилт нь ажлын байртай болох баталгааг нэмэгдүүлж байна.

Ажилгүйдлийг бууруулж байгаа нэг салбар бол хөдөө аж ахуйн салбар байна. Эдийн засагт бүтээмж өндөртэй, гэвч ажилчдыг багаар шингээдэг салбар жишээ нь уул, уурхайн салбар юм. Энэ салбар ажилгүйдлийг бууруулж чаддаггүй. Харин бүтээмж багатай, гэвч ажилчдыг ихээр шингээдэг салбарууд жишээ нь хөдөө аж ахуй, үйлчилгээний салбар нь хэдийгээр эдийн засгийн өсөлтөнд сул нөлөөлдөгч олон хүнийг тэжээж байна.

Ажиллагсдыг байгууллагын өмчийн хэлбэрээр нь авч үзэхэд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийт ажиллагсдад эзлэх хувийн жин өндөр байна. Тиймээс ажилгүйчүүдийг энэ чиглэлээр ажилтай болгох боломжийг хайх хэрэгтэй байна. Ажил эрхлэлтийн судалгаанаас үзэхэд шинээр бий болж буй ажлын байр нь ихэвчлэн сэлгээний шинж чанартай, өөрөөр хэлбэл, нэг хүний оронд нөгөө хүн ажилд орох гэх мэт.

Цаг хугацаанаас хамааруулсан ажилгүйдлийн үнэлгээнээс үзэхэд цаг хугацаа өнгөрөх тусам ажилгүйдэл буурч байна. Гэвч энд хурд буюу ямар хугацаанд хэдэн хүн шинээр ажилд орж байгаа нь чухал.

Ажилгүйдлийг дотоодын нийт бүтээгдэхүүн, үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн тооноос хамааруулсан үнэлгээнээс үзэхэд ажилгүйдэл нь үл хамаарагч хоёр хүчин зүйлээс урвуу хамааралтай нь харагдаж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт эдийн засгийн өсөлтийг илэрхийлдэг. Тиймээс эдийн засаг хэдий чинээ өснө, бидний

<sup>7</sup> Завхан статистикийн эмхэтгэл

амьдралын нөхцөл байдал тэр хэмжээгээр сайн, сайхан байна. Түүний дам нөлөөгөөр ажилгүйдэл буурч, ажил эрхлэлт нэмэгдэнэ. Эдийн засгийн тааламжтай нөхцөл бий болсны үр дүнд аливаа байгууллага оршин тогтнож, үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрддэг. Ийм байдал бий болсноор ажилгүйдэл багасах үндэслэл болно.

Ажилгүйдэл ба ажил эрхлэлтийг хүн ам зүйн ачаалал, хүн ам зүйн нас, хүйсийн суврагатай холбон авч үзэхэд нэг тэжээгч хэт ачаалалтай байна. Мөн хүн ам зүйн нас хүйсийн суврагыг авч үзэхэд нийт хүн амын дийлэнх хэсгийг хөдөлмөрийн насны залуучууд эзэлж байгаа ба энэ насныхан мөн л ажилгүй байна. Тиймээс эдгээр залуучуудыг ажилтай болговол аймгийн хувьд, цаашлаад улс орны эдийн засгийн өсөлт, хөгжилд эерэгээр нөлөөлнө.

Манай орны өндөр мэдлэг, боловсролтой

боловсон хүчин гадаадад гарч ажилладаг бөгөөд тэдний оронд мөн өөр өндөр түвшний мэргэжилтнийг гаднаас авч ажиллуулдаг. Энэ ажиллах хүчинд чадавхийг ба боломжийг бий болгохгүй байна. Шинээр ажлын байр бий болгогчийг урамшуулах бодлого (бага (1,25%) хүүтэй зээл олгох. Хувь хүнд 3 сая, ААНэгж байгууллагад 10 сая төг) хэрэглэх; ажилгүйчүүдийг ХЭАлбанд бүртгүүлэх ач холбогдлыг нийтэд сурталчилах: ХЭАлбанд нэг жилээс дээш хугацаанд бүртгэлтэй байсан 18-45 насны ажилгүй хүнийг ажилтай болгосноор тухайн хүний 6 сарын цалингийн 60 хувийг хөдөлмөр эрхлэлтийн албанаас олгодогийг нийтэд, тэрдундаа ажил олгогчид сурталчилах; ажлын байр бий болгоход чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг татах; мэргэжилгүй болон дахин мэргэжил олох хүсэлтэй байгаа хүмүүст дахин мэргэжил олгох сургалт зохион байгуулж ажлын байраар хангах зэрэг асуудал руу хандаж болно.

### Ашигласан материал

МУ-ын ЗГ, НҮБХХ, 2007. Монголын хүний хөгжлийн илтгэл 2007, Ажил эрхлэлт, ядуурал, Монгол Улсын Засгийн Газар, НҮБХХ, Улаанбаатар

МУИС, ЭЗС. 2006. ЭДИЙН ЗАСАГ: онол, практик 2006 №259 (15)

Н. Содномдорж, 2006. Хөдөлмөрийн эдийн засаг, Хөдөлмөрийн дээд сургууль, Улаанбаатар

ҮСХ. 1992-2008. Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 1992-2008, Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Улаанбаатар

ҮСХ. 2009. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2008-2009 он, Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Улаанбаатар